



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2023 оны 02 дугаар сарын 01  
№05 (1253)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТАМГЫН ГАЗАР



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

26.	Шүүх шинжилгээний тухай /Шинэчилсэн найруулга/	116
27.	Шүүхийн шинжилгээний тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай	253
28.	Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	254
29.	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	257
30.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай	258
31.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	259
32.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	269
33.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	271
34.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	272
35.	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	274
36.	Улсын гэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	276
37.	Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	281
38.	Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	282

39.	Галт зэвсгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		283
40.	Цэргийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		284
41.	Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		285
42.	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		286
43.	Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай		288
44.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		289
45.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт оруулах тухай		291
46.	Зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		292
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
47.	“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 84	293
48.	Хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай	Дугаар 06	295
49.	Орхоны хөндийд “Шинэ Хархорум” хот байгуулах тухай	Дугаар 07	297





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2022 оны 12 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

#### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь шүүх шинжилгээ хийх, хүрээлэн байгаа орчны хохирлыг тооцох, сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох, шүүх шинжилгээ хийх үндэслэл, журам болон шүүх шинжилгээний байгууллагын тогтолцоо, чиг үүрэг, алба хаагчийн эрх зүйн байдлыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

#### 2 дугаар зүйл.Шүүх шинжилгээний хууль тогтоомж

2.1.Шүүх шинжилгээний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Төрийн албаны тухай хууль<sup>2</sup>, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль<sup>3</sup>, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>4</sup>, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль<sup>5</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль<sup>6</sup>, Арбитрын тухай хууль<sup>7</sup>, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль<sup>8</sup>, Цагдаагийн албаны тухай хууль<sup>9</sup>, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль<sup>10</sup>, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль<sup>11</sup>, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

<sup>1</sup>Монгол Улсын Үндсэн хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төрийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup>Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

<sup>4</sup>Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2002 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>5</sup>Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2016 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

<sup>6</sup>Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>7</sup>Арбитрын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

<sup>8</sup>Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

<sup>9</sup>Цагдаагийн албаны тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>10</sup>Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 1994 оны 8 дугаарт нийтлэгдсэн.

<sup>11</sup>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

### **3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэ хууль үйлчилнэ.

3.2.Шүүх шинжилгээний байгууллага эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ тооцох болон гэмт хэргийн улмаас сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтооход энэ хууль үйлчилнэ.

3.3.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад шүүх шинжилгээний үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд энэ хууль үйлчилнэ.

### **4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт**

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

4.1.1.“шүүх шинжилгээ” гэж эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан /цаашид “зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд” гэх/-ы хүсэлтэд заасан шинжилгээний объектод тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

4.1.2.“тусгай мэдлэг” гэж хэргийн бодит байдлыг тогтооход шаардлагатай шинжлэх ухаан, техник технологи, урлаг, түүх, соёл, эдийн засгийн болон бусад тодорхой салбарын мэдлэгийг;

4.1.3.“хохирлын үнэлгээнд хийх шинжилгээ” гэж эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хөрөнгө, хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ тооцох, сэтгэцэд учирсан хор уршгийн үнэлгээнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргах үйл ажиллагааг;

4.1.4.“шинжээч” гэж шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаар хуульд заасан журмын дагуу томилогдсон тусгай мэдлэг бүхий хүнийг;

4.1.5.“мэргэжилтэн” гэж эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлтээр оролцох тусгай мэдлэг бүхий хүнийг;

4.1.6.“шүүх шинжилгээний байгууллагын шинжээч” гэж шинжлэх ухааны тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн, эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох шүүх шинжилгээний байгууллага /цаашид “шинжилгээний байгууллага” гэх/-ын алба хаагчийг;

4.1.7.“шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд” гэж мөрдөгч, прокурор, шүүгч, шүүх, арбитр болон зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийг;

4.1.8.“шинжээчийн дүгнэлт” гэж хуульд заасан шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг хангаж, тусгай мэдлэгийн хүрээнд гаргасан нотлох баримтын эх сурвалж болох баримт бичгийг;

4.1.9.“харьцуулан шинжлэх хэв загвар, дээж” гэж шинжилгээ хийгдэж байгаа хүн, амьтан, ургамлын хэсэг, амьтан, ургамлын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, цогцос, компьютерын программ, цахим мэдээлэл, өгөгдөл, гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, баримт бичиг, химийн хорт болон аюултай бодис зэрэг шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад шинжээчид зайлшгүй шаардлагатай, хуульд заасан журмын дагуу хураан авч бэхжүүлсэн бусад объектыг;

4.1.10.“шинжилгээний объектын гэмтэл” гэж үзлэг, шинжилгээ, туршилтын явцад объектын хэлбэр, хийц, хэмжээ, шинж чанар алдагдах, өөрчлөгдөхийг;

4.1.11.“шинжилгээний объектын хорогдол” гэж үзлэг, шинжилгээ, туршилтын явцад объектын тоо хэмжээ багасах, дуусах, устгахыг.

## **5 дугаар зүйл. Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд баримтлах зарчим**

5.1. Шүүх шинжилгээний үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална:

5.1.1. хууль дээдлэх;

5.1.2. хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх;

5.1.3.хараат бус байх;  
5.1.4.шинжээчийн ёс зүйг баримтлах;  
5.1.5.шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийх;

5.1.6.нууцыг хадгалах;  
5.1.7.аюулгүй байдлыг хангах.

5.2.Энэ хуулийн 5.1-д заасан зарчим нь дараах байдлаар хэрэгжинэ:

5.2.1.шүүх шинжилгээний үйл ажиллагаатай холбогдсон харилцааг тусгайлсан хуулиар зохицуулах;

5.2.2.шүүх шинжилгээг зөвхөн хуульд заасан үндэслэл журмын дагуу хийх;

5.2.3.шүүх шинжилгээний байгууллага, шинжээч, мэргэжлийн байгууллага нь шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэн зөрчихгүй байх нөхцөлийг бүрдүүлэн ажиллах;

5.2.4.шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад аливаа этгээд хөндлөнгөөс оролцох, заавар, чиглэл, зөвлөгөө өгөх зэргээр нөлөөлөхийг хориглох;

5.2.5.шүүх шинжилгээний байгууллага, шинжээч, мэргэжлийн байгууллага нь иргэн, хуулийн этгээдээс хууль тогтоомж болон олон улсын гэрээнд заасны дагуу нийлүүлэх эд хөрөнгө, зээл, тусламж, олон улсын болон хүмүүнлэгийн тусламжийн төсөл, хөтөлбөрөөс бусад хэлбэрээр хандив, санхүүгийн туслалцаа авахыг хориглох;

5.2.6.шинжээч шүүх шинжилгээний үр дүнд нөлөөлөхөөр хуульд заасан нөхцөл байдал илэрвэл шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;

5.2.7.шүүх шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа шинжилгээний жишиг хугацааг удирдлага болгон шинжилгээг шинжилгээний үр дүнд нөлөөлөхөөргүй боломжит богино хугацаанд шуурхай хийж гүйцэтгэх;

5.2.8.шинжээч шинжилгээ хийхдээ шинжлэх ухааны үндэслэл бүхий арга аргачлал, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг баримтлан шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, дүгнэлт гаргах бөгөөд дүгнэлтийн үндэслэлийг шинжээч өөрөө хариуцах;

5.2.9. шинжээч шүүх шинжилгээний байгууллага, шүүх, прокурор, мөрдөгчид хүсэлт гарган аюулгүй байдлаа хамгаалуулах.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ШҮҮХ ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ, НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **6 дугаар зүйл. Шүүх шинжилгээ хийх үндэслэл**

6.1. Шүүх шинжилгээ /цаашид “шинжилгээ” гэх/ хийх үндэслэл нь шинжилгээ хийлгэх шийдвэр байна. Шинжилгээ хийлгэх шийдвэрт мөрдөгч, прокурор, шүүх, арбитрын тогтоол, шүүгчийн захирамж, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээдийн хүсэлт хамаарна.

6.2. Хүн, хуулийн этгээдээс шинжээчийн дүгнэлтийн талаар шинжилгээний байгууллагад гаргасан гомдол, хүсэлт нь шинжилгээ хийх үндэслэл болохгүй.

### **7 дугаар зүйл. Шинжилгээ хийлгэх шийдвэр гаргах**

7.1. Шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 4.1.7-д заасан эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх шийдвэр гаргана.

7.2. Шинжилгээ хийлгэх шийдвэрийг шинжилгээний төрөл тус бүрээр гаргана.

7.3. Шинжилгээ хийлгэх шийдвэрт дараах зүйлийг тусгана:

7.3.1. шинжилгээ хийлгэх үндэслэл;

7.3.2. шинжилгээний төрөл, хэлбэр;

7.3.3. энэ хуулийн 16.7-д заасан жишиг хугацааны хүрээнд тогтоосон шинжилгээ хийлгэх хугацаа;

7.3.4. шинжилгээ хийх байгууллагын нэр;

7.3.5. шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр шинжилгээ хийлгэх бол байгууллага, шинжээчийн нэр;

7.3.6. шинжээчид тавих асуулт;

7.3.7. хэмжээ, хаяг, байршил зэрэг шинжилгээний объектын талаарх мэдээлэл.

### **8 дугаар зүйл. Шинжилгээ хийх этгээд**

8.1. Шинжилгээг шинжилгээний байгууллагаар, эсхүл шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэнэ.

8.2.Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдэд дараах этгээд хамаарна:

8.2.1.тухайн хэрэгт хувийн ашиг сонирхолгүй тусгай мэдлэг бүхий хүн;

8.2.2.энэ хуулийн 11.1-д заасны дагуу шинжилгээ хийх эрх авсан шинжээч;

8.2.3.төрийн байгууллагад ажиллаж байгаа тусгай мэдлэг бүхий хүн;

8.2.4.мэргэжлийн байгууллага.

8.3.Шинжилгээний байгууллагад хийх шинжилгээний жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

8.4.Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэж болох шинжилгээний жагсаалтыг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: -Энэ хуулийн 8.2.4-т заасан “мэргэжлийн байгууллага” гэж тухайн хэрэг, маргаанд хамааралгүй салбар яам, агентлаг, тусгай чиг үүрэг бүхий байгууллага, эсхүл эрх бүхий байгууллагаас мэргэжлийн байгууллагын эрх авсан хуулийн этгээдийг ойлгоно.

### **9 дүгээр зүйл.Шинжилгээг шинжилгээний байгууллагаар хийлгэх**

9.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэх шийдвэрийг шинжилгээний объектын хамт шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

9.2.Шинжилгээний байгууллага нь шинжилгээг шинжилгээний төрөл тус бүрээр урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах программ хангамж ашиглан шинжээч, эсхүл шинжээчдийн багт хуваарилна.

9.3.Энэ хуулийн 9.2-т заасан программ нь хуваарилагдах шинжээчийг урьдчилан мэдэх боломжгүй, санамсаргүй тохиолдлоор хуваарилах нөхцөлийг бүрдүүлж дараах шаардлага хангасан байна:

9.3.1.шинжилгээний байгууллага шинжилгээ хийлгэх шийдвэр, шинжилгээний объектыг хүлээн авсан даруй хуваарилалтыг хийх, хуваарилалтыг өөрчлөх боломжгүй хамгаалалттай байх, хэзээ, хэрхэн хуваарилагдсан тухай баримтыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд шууд өгөх боломжтой байх;

9.3.2. шинжилгээг хуваарилахдаа шинжээчийн мэргэжил, ажлын дадлага, туршлага, мэргэшсэн байдал, эрдмийн зэрэг, цол, ажлын ачаалал зэргийг харгалзах;

9.3.3. цахимаар хийгдсэн хуваарилалтыг гагцхүү энэ хуульд заасан журмаар зөвшөөрөгдсөн татгалзал, эсхүл шинжээч, шинжээчийн бүрэлдэхүүн солигдох нөхцөлд өөрчлөх бөгөөд уг өөрчлөлт нь хүний нөлөөллөөс ангид, ил тод, баримтжуулсан байх.

9.4. Шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан шинжээчид эрх, үүргийг тайлбарлан өгч зориуд худал дүгнэлт гаргасан тохиолдолд түүнд хүлээлгэх хариуцлагыг урьдчилан сануулна.

9.5. Шинжээчийн дүгнэлтийг баталгаажуулснаар тухайн шинжилгээг дууссанд тооцно.

9.6. Энэ хуулийн 9.2-т заасан шинжээчид цахим программ хангамж ашиглан шинжилгээг хуваарилах журам болон энэ хуулийн 9.3-т заасан нөхцөл, шаардлагыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.

Тайлбар: -Энэ хуульд заасан “шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан” гэж энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэгч шинжилгээний байгууллагын алба хаагчийг ойлгоно.

## **10 дугаар зүйл. Шинжилгээг шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдээр хийлгэх**

10.1. Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд энэ хуулийн 8.4-т заасан жагсаалтад хамаарах шинжилгээг хийнэ.

10.2. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд энэ хуулийн 8.2-т заасан этгээдэд шинжилгээ хийлгэх санал тавьж, хувийн баримт бичиг, тусгай мэдлэг, мэргэжил, чадварыг нотолсон баримт бичиг, шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах үндэслэл, шинжээчээр ажиллахыг зөвшөөрч байгаа эсэхийг урьдчилан тодруулж, баримтжуулна.

10.3. Энэ хуулийн 10.2-т заасан үйл ажиллагааг явуулсны дараа шинжилгээ хийлгэх шийдвэр гаргаж, энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан этгээдэд, мэргэжлийн байгууллагын удирдлага, эсхүл төлөөлөх эрх бүхий этгээдэд шинжилгээ хийлгэх шийдвэрийг гардуулан өгч, эрх, үүрэг, хариуцлагыг урьдчилан сануулж, гарын үсэг зуруулна.

10.4.Энэ хуулийн 10.3-т заасны дагуу шинжээчээр томилогдсон этгээд энэ хуульд заасан журмын дагуу шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

10.5.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд энэ хуулийн 10.4-т заасан этгээдийн саналыг харгалзан шинжилгээ хийх жишиг хугацаанд багтаан шинжилгээ хийх хугацааг тогтооно.

10.6.Шинжээч шинжилгээ хийх явцад шинжилгээтэй холбоотой хүсэлт гаргавал түүнийг томилсон этгээд хуульд заасан журмын дагуу тэмдэглэл үйлдэх үүрэгтэй.

10.7.Энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан этгээд нь шинжээчээр томилогдсон тохиолдолд хуульд заасан шинжээчийн эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

10.8.Энэ зүйлд заасан журмыг зөрчиж шинжээч томилохыг хориглоно.

### **11 дүгээр зүйл. Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох**

11.1.Тусгай мэдлэг бүхий хүнд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, сунгах, хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах эрх бүхий орон тооны бус зөвлөл /цаашид “зөвлөл” гэх/ ажиллана. Зөвлөлийн саналыг үндэслэн шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр 5 жилийн хугацаагаар олгоно.

11.2.Энэ хуулийн 11.1-д заасан зөвлөл нь тухайн салбарын төрийн захиргааны төв байгууллагаас санал болгосон эрдэмтдийн төлөөлөл, ашгийн төлөө бус хуулийн этгээд болон шүүх шинжилгээний байгууллагын төлөөлөөс бүрдэх бөгөөд зөвлөлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний шийдвэрээр байгуулна.

11.3.Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигчид гэрчилгээ, шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, дүгнэлтийн маягт олгоно.

11.4.Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авах Монгол Улсын иргэн дараах шаардлагыг хангасан байна:

11.4.1.мэргэжлээрээ 10, түүнээс дээш жил ажилласан туршлагатай байх;



11.4.2.шүүх шинжилгээний сургалтад хамрагдсан байх;  
11.4.3.мэргэжил, мэргэшлийн зэрэг, цолтой байх;  
11.4.4.сэтгэц, зан үйлийн эмгэггүй байх;  
11.4.5.ял шийтгэлгүй байх;  
11.4.6.тусгай мэдлэг эзэмшсэнийг гэрчлэх мэргэжлийн үнэмлэх, дипломтой байх.

11.5.Дараах тохиолдолд шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр түдгэлзүүлнэ:

11.5.1.шинжээч хуульд заасан шинжээчийн үүргээ биелүүлээгүй, эсхүл шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт хангаагүй дүгнэлт гаргасан бол 3-аас 6 сарын хугацаагаар;

11.5.2.шинжээч Эрүүгийн хуульд заасан гэмт хэрэгт яллагдагчаар татагдсан тохиолдолд эрх бүхий байгууллага эцэслэн шийдвэр гаргах хүртэл хугацаагаар;

11.5.3.хуульд заасан бусад.

11.6.Энэ хуулийн 11.5.1, 11.5.2-т заасан хугацаа дууссан бол түдгэлзүүлсэн шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр сэргээнэ.

11.7.Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг зөвлөлийн санал, дүгнэлтийг үндэслэн шүүх шинжилгээний төв байгууллагын даргын шийдвэрээр дараах тохиолдолд хүчингүй болгоно:

11.7.1.шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлөө цуцлуулах хүсэлт гаргасан;

11.7.2.шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

11.7.3.хоёр, түүнээс дээш удаа шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт хангаагүй дүгнэлт гаргасан;

11.7.4.шинжээчийн ёс зүй, хууль тогтоомж, ноцтой зөрчсөн нь нотлогдсон;

11.7.5.шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;



11.7.6. шинжээчийн иргэний эрх зүйн чадамжийг хязгаарласан, эсхүл иргэний эрх зүйн чадамжгүйд тооцсон шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

11.7.7. эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах тухай шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болсон;

11.7.8. гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож, шүүхийн шийтгэх тогтоол хуулийн хүчин төгөлдөр болсон.

11.8. Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл эзэмшигч нас барсан бол тухайн эрх дуусгавар болно.

11.9. Зөвлөл нь энэ хуулийн 11.7.3, 11.7.4, 11.7.5-д заасан тохиолдолд дүгнэлт, мөн зүйлийн 11.5.1, 11.5.2, 11.7.1, 11.7.2, 11.7.6, 11.7.7, 11.7.8-д заасан тохиолдолд санал гаргана.

11.10. Зөвлөл нь шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн хугацааг сунгуулах тухай хүсэлтийг үндэслэн уг зөвшөөрлийн хугацааг сунгах эсэх талаар гаргасан саналаа шүүх шинжилгээний төв байгууллагын даргад хүргүүлж, шийдвэрлүүлнэ.

11.11. Шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгосон талаарх мэдээллийг шүүх шинжилгээний төв байгууллага цахимаар нийтэд нээлттэй мэдээлнэ.

11.12. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дараах журам, маягтын загварыг батална:

11.12.1. мэдээллийн сан үүсгэх, мэдээллийн санг нийтэд танилцуулах, шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, маягт ашиглах журам;

11.12.2. зөвлөлийн үйл ажиллагааны журам;

11.12.3. шинжээчийн хувийн дугаар бүхий тэмдэг, дүгнэлтийн маягтын загвар.

## **12 дугаар зүйл. Шинжилгээний объектод тавих нийтлэг шаардлага**

12.1. Шинжилгээний объект шинж чанараа амархан алдах, устаж үгүй болохоор байвал түүнийг бэхжүүлж авсны дараа шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний байгууллага, шинжээчид даруй хүргүүлж, шинжилгээг хийлгэнэ.

12.2.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний объектын шинжилгээ хийх байгууллага, шинжээчид хүргүүлэх боломжгүй бол шинжээчийг шинжилгээний объектын оршин байгаа газар, байршил, объектод чөлөөтэй нэвтрэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангана.

12.3.Шинжилгээний объект дараах нийтлэг шаардлагыг хангасан байна:

12.3.1.шинжилгээ хийхэд шаардагдах тоо, хэмжээ, чанарын үзүүлэлтийг хангасан байх;

12.3.2.эх хувь буюу биет байдлаар, эсхүл энэ хуульд заасан тусгай шаардлагыг хангасан байх;

12.3.3.эдийн засгийн шинжилгээний объектын хувьд эрх бүхий байгууллагын акт, дүгнэлт гарсан байх.

12.4.Дараах объектод шинжилгээ хийлгэх бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний байгууллага, шинжээчид урьдчилан мэдэгдэж, шинжилгээний объектын хүргүүлэх эсэхийг шийдвэрлэнэ:

12.4.1.галт зэвсэг, сум, дагалдах хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, тэдгээрийн хэрэгсэл, протехникийн хэрэгсэл, цацраг идэвхт үүсгүүр, хими, биологийн хорт бодис зэрэг хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх объект;

12.4.2.тээврийн хэрэгсэл, түүний овор хэмжээ ихтэй эд анги;

12.4.3.мал, амьтан, ургамал, соёлын үнэт зүйл, түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл болон түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйл, бусад онцлог бүхий объект;

12.4.4.овор хэмжээ ихтэй объект.

12.5.Энэ хуулийн 12.4.1-д заасан объектын жагсаалтыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Тайлбар: -Энэ хуулийн 12.1-д заасан “шинжилгээний объект” гэж шинжилгээ хийж байгаа ул мөр, эд мөрийн баримт, хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг, баримт бичиг, цахим технологийн техник, программ хангамж, цахим хэлбэрт байгаа мэдээлэл, гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг, амьтан, ургамал, хүний бие, цогцос болон түүний хэсэг, харьцуулан шинжлэх хэв загвар, дээж, хэргийн бусад материалыг ойлгоно.

### **13 дугаар зүйл. Шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах**

13.1. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний объектын бүрэн бүтэн байдал, чанар, нууцлалыг бүрэн хангаж, зориулалтын уут, дугтуй, хайрцаг, тусгайлан бэлтгэсэн сав зэрэгт тус тусад нь стандарт, журмын дагуу битүүмжилж, шинжилгээ хийлгэх шийдвэрийн хамт энэ хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллагад шууд хүргүүлнэ.

13.2. Шинжилгээний объектыг шинжилгээнд хүргүүлэх хүртэл хугацаанд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, шинжилгээний байгууллага хүлээн авч шинжээчид хүлээлгэн өгөх, шинжилгээ хийсний дараа шинжээчээс хүлээн авч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд буцаан хүргүүлэх хүртэлх хугацаанд бүртгэл, мэдээллийн ажилтан, үзлэг, шинжилгээ хийх явцад шинжээч зохих журмын дагуу хадгалж, бүрэн бүтэн байдлыг хариуцна.

13.3. Шинж чанараа алдаж, шинжилгээнд дахин ашиглах боломжгүй болох эрсдэлтэй шинжилгээний объектоос сорьц авч, шинжилгээний адилтгал, мэдээллийн санд хадгалах бөгөөд түүнийг шинжилгээнд ашиглаж болно.

13.4. Биологийн гаралтай эд мөрийн баримт болох цус, үрийн шингэн, шүлс, үс, яс, эд, эс болон бусад зүйлийг адилтгал, мэдээллийн санд авч хадгална.

13.5. Шинж чанараа алдаж, шинжилгээнд ашиглах боломжгүй болсон, эсхүл энэ хуулийн 13.4-т заасан адилтгал, мэдээллийн санд авч хадгалснаас үлдсэн биологийн дээжийг шинжилгээ хийж дууссаны дараа шүүгч, эсхүл прокурорын зөвшөөрлөөр устгана.

13.6. Энэ хуулийн 13.5-д заасан зөвшөөрөл олгосноос бусад шинжилгээний объектыг устгахыг хориглоно.

13.7. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад өөрийн биеэр болон тухайн байгууллагаас томилогдсон эрх бүхий этгээдээр, эсхүл тусгай шуудангаар хүргүүлж, шинжилгээ хийж дууссаны дараа шинжээчийн дүгнэлтийн хамт буцаан авна.

13.8. Шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлэх, хадгалах, шилжүүлэх, устгах журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор хамтран батална.



#### **14 дүгээр зүйл.Шинжилгээ хийх**

14.1.Шинжээч хүлээн авсан шинжилгээний объектыг гэрэл зураг болон бусад арга хэрэгслээр бэхжүүлсний дараа батлагдсан шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт, журмын дагуу шинжилгээ хийнэ.

14.2.Шинжилгээний үр дүнд шинжилгээнд ирүүлсэн объектод гэмтэл, эсхүл хорогдол үүсэхээр байвал шинжээч шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд энэ талаар урьдчилан мэдэгдэнэ.

14.3.Шинжээч шаардлагатай тохиолдолд хуульд заасан журмыг баримтлан харьцуулан шинжлэх хэв загвар, дээж авч, дүгнэлт гаргахдаа ашиглаж болно.

14.4.Шинжилгээний байгууллага, шинжээч харьцуулан шинжлэх хэв загвар, дээжийг шинжилгээ хийж дууссаны дараа шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд буцаана.

14.5.Лабораторид хийгдэх шинжилгээг стандартын шаардлага хангасан техник, тоног төхөөрөмж бүхий орчинд хийнэ.

14.6.Шинжилгээний техник, тоног төхөөрөмж бүхий лаборатори нь магадлан итгэмжлэгдсэн байна.

14.7.Лабораторийн үзлэг шинжилгээний явцыг дууны, дүрсний, эсхүл дуу-дүрсний аргаар бэхжүүлж, хадгална.

14.8.Шинжилгээ хийх явцад шинжээчийн буруутай үйл ажиллагаанаас бусад тохиолдолд шинжилгээний объектод үүссэн гэмтэл, хорогдлыг шинжилгээний байгууллага, шинжээч хариуцахгүй.

14.9.Хими, физик, биологи, дезоксирибонуклейны хүчил /ДНХ/, бактериологийн зэрэг лабораторийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

#### **15 дугаар зүйл.Шинжилгээний стандарт**

15.1.Шинжээч шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг мөрдлөг болгоно.

15.2.Шинжилгээний магадлан итгэмжлэгдсэн лаборатори, тоног төхөөрөмжөөс гарсан шинжилгээний дүнг шинжээч өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд үнэлж, дүгнэлт гаргана.

15.3.Шинжилгээ хийх үйл ажиллагааны стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага батална.

### **16 дугаар зүйл. Шинжилгээ хийх хугацаа**

16.1. Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний объектын тоо хэмжээ, шинжилгээний цар хүрээ, онцлогийг харгалзан шинжилгээ хийх жишиг хугацааг үндэслэн шинжилгээ хийх хугацааг тогтооно.

16.2. Шинжилгээ хийлгэх шийдвэрийг шинжилгээний объектын хамт энэ хуульд заасан шаардлага хангахуйц байдлаар шинжилгээний байгууллагад ирүүлсэн, эсхүл хүргүүлэх боломжгүй объектын оршин байгаа газарт очсон өдрөөс эхлэн шинжилгээний хугацааг тоолно.

16.3. Шинжээч энэ хуулийн 16.1-д заасны дагуу тогтоосон хугацаанд шинжээчийн дүгнэлт гаргах боломжгүй бол хугацаа дуусахаас өмнө шинжилгээний байгууллагын хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд хугацааг сунгуулах тухай хүсэлтээ өөрийн биеэр мэдэгдэж, хүсэлтээ тайлбарлана.

16.4. Энэ хуулийн 16.3-т заасан хүсэлтийг хүлээн авсан шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан хугацаа сунгах үндэслэлтэй эсэхийг хянаж, шинжилгээ хийх хугацааг энэ хуулийн 16.1-д заасныг үндэслэн сунгаж, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд хугацаа дуусахаас өмнө даруй бичгээр мэдэгдэнэ.

16.5. Шинжилгээний байгууллагаас бусад этгээдээр хийлгэх шинжилгээний хугацааг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэж, сунгуулна.

16.6. Энэ хуулийн 16.5-д заасан хүсэлтийг хүлээн авсан шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хугацааг сунгах эсэхийг шийдвэрлэнэ.

16.7. Шинжилгээний төрөл тус бүрээр гаргасан шинжилгээ хийх жишиг хугацааг шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнтэй хамтран батална.

### **17 дугаар зүйл. Шинжээч дүгнэлт гаргах**

17.1. Шинжээчийн дүгнэлт нь шинжилгээний бодит үр дүнг тусгасан, шинжлэх ухааны тодорхой арга зүйд тулгуурласан, шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнд гарсан байна.

17.2.Шинжээч гаргасан дүгнэлтийнхээ үндэслэлийг хариуцна.

17.3.Шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээний явц, үр дүнг үндэслэн дүгнэлтээ бичгээр гаргаж, гарын үсэг зурж, хувийн болон байгууллагын баталгааны тэмдгээр баталгаажуулна.

17.4.Энэ хуулийн 8.2.2-т заасан шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан тохиолдолд дүгнэлтэд гарын үсэг зурж, хувийн тэмдгээр, 8.2.1, 8.2.3-т заасан этгээд дүгнэлтийг гарын үсгээр, 8.2.4-т заасан этгээд шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан бол дүгнэлтийг гарын үсэг, байгууллагын тэмдгээр баталгаажуулна.

17.5.Шинжээчийн дүгнэлттэй холбогдуулан гаргах өргөдөл, гомдлыг энэ хуулийн 4.1.7-д заасан эрх бүхий этгээдэд гаргана.

17.6.Шинжээч дүгнэлтээ хоёр хувь үйлдэж, нэг хувийг шинжилгээ хийлгэх шийдвэр гаргасан этгээдэд хүргүүлж, үлдэх хувийг шинжилгээний байгууллагын архивт хадгалуулна.

## **18 дугаар зүйл.Шинжээчийн дүгнэлтийн агуулга**

18.1.Шинжээчийн дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

18.1.1.шинжилгээ хийсэн он, сар, өдөр, газар;

18.1.2.шинжилгээ хийх болсон үндэслэл;

18.1.3.шинжилгээний төрөл, хэлбэр;

18.1.4.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн талаарх

мэдээлэл;

18.1.5.эцэг /эх/, өөрийн нэр, боловсрол, мэргэжил, ажилласан жил, эрдмийн зэрэг, цол, албан тушаал зэрэг шинжээчийн талаарх мэдээлэл;

18.1.6.шинжилгээний объектын талаарх мэдээлэл;

18.1.7.шинжилгээний объект ба хэргийн материалыг шинжилсэн явц;

18.1.8.шинжилгээний явцад байлцсан хэргийн оролцогчийн талаарх мэдээлэл;

18.1.9.шинжээчид тавьсан асуулт тус бүрд өгсөн хариулт, түүний үндэслэл;

18.1.10.хүний биед хийсэн шинжээчийн дүгнэлтэд шинжилгээ хийлгэсэн этгээдээс шинжилгээ хийхэд шаардлагатай харьцуулан шинжлэх хэв загвар, дээж авсан тухай мэдээлэл;

18.1.11.тоон болон чанарын үзүүлэлт;  
18.1.12.бусад.

18.2.Шинжилгээ хийх явцад шинжээч уг хэрэгт ач холбогдол бүхий бусад зүйлийг олж тогтоосон бол энэ талаар асуулт тавиагүй ч дүгнэлтэд тусгана.

18.3.Шинжилгээ хийх явцад хэрэглэсэн арга, аргачлал, тэдгээрийн үр дүнг харуулсан гэрэл зургийн үзүүлэлт нь шинжээчийн дүгнэлтийн бүрэлдэхүүн хэсэг болох ба түүнийг хоёр хувь үйлдэн дүгнэлтийн хувь тус бүрд хавсаргана.

18.4.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хуулиар хориглосноос бусад тохиолдолд шүүх, прокурорын зөвшөөрснөөр шинжилгээний дүгнэлтийг хийх журам, шинжлэх ухааны үндэслэлийн талаар хэргийн оролцогчоос бусад этгээдэд мэдээлэл өгч болно.

### **19 дүгээр зүйл.Шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах**

19.1.Шинжээч дараах үндэслэл байвал шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзана:

19.1.1.уг хэргийг хянан шийдвэрлэх болон шалган шийдвэрлэх ажиллагаанд зохигч, гуравдагч этгээд, гэрч, хохирогч, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч, иргэдийн төлөөлөгч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий этгээд, мөрдөгч, прокурор, шүүгчийн хувиар өмнө нь оролцсон бол;

19.1.2.хэрэг хянан шийдвэрлэх болон шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогчийн гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн бол;

19.1.3.албан тушаалын болон бусад байдлаар хэргийн оролцогчийн нөлөөнд байгаа, эсхүл нөлөөлөхөөр бол;

19.1.4.хэргийн оролцогчтой хувийн харилцаатай, эсхүл тухайн шинжилгээг бүрэн, бодитой, шинжлэх ухааны үндэслэлтэй хийж чадах эсэх талаар үндэслэл бүхий эргэлзээтэй бол;

19.1.5.шинжээчийн шинжилгээ хийхээр томилогдохоос өмнө хийсэн шалгалтын материал тухайн хэрэг үүсгэх үндэслэл болсон бол;



19.1.6. шинжилгээний объект нь энэ хуульд заасан нийтлэг болон тусгай шаардлага хангахгүй бол;

19.1.7. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуулт тодорхойгүй, тавьсан асуултад шинжлэх ухааны арга, хэрэгсэл ашиглан хариулах боломжгүй бол;

19.1.8. шинжилгээний цар хүрээ, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуулт нь шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тусгай мэдлэгийн хүрээнд хамаарахгүй бол;

19.1.9. хууль тогтоомж хэрэглэх, түүний зүйл, хэсэг, заалтыг тайлбарлуулахаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан бол.

19.2. Шинжээч энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.3, 19.1.4, 19.1.5-д заасан үндэслэлээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээ хийлгэхээр өөр байгууллага, шинжээчийг томилно.

19.3. Шинжилгээний байгууллагын шинжээч энэ хуулийн 19.1.6, 19.1.7, 19.1.8, 19.1.9-д заасан үндэслэл байвал үндэслэлээ тодорхой зааж шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзаж, шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтанд даруй мэдэгдэнэ.

19.4. Шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээд энэ хуулийн 19.1-д заасан үндэслэл байвал үндэслэлээ тодорхой зааж шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзаж, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд даруй мэдэгдэнэ.

19.5. Энэ хуулийн 19.1.1, 19.1.2, 19.1.3, 19.1.4-т заасан үндэслэл байвал хэргийн оролцогч, тэдний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч нь байгууллага, шинжээчийг татгалзан гаргах тухай хүсэлтийг хуульд заасан журмын дагуу гаргаж болно.

19.6. Шинжээч энэ хуулийн 19.1-д зааснаас бусад үндэслэлээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзахыг хориглоно.

19.7. Мэргэжлийн байгууллага, шинжээчийг татгалзан гаргах хүсэлтийг хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

## **20 дугаар зүйл.Шинжилгээний нууцлал**

20.1.Шинжилгээний байгууллага, шинжээч, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллага шинжилгээний явц, үр дүнгийн нууцлалыг хангаж ажиллана.

20.2.Шинжилгээний байгууллага, шинжээч, мэргэжилтэн, мэргэжлийн байгууллага шинжилгээ хийх явцад олж мэдсэн хуулиар хамгаалагдсан төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хуулиар хамгаалагдсан хүний эмзэг мэдээллийг задруулахгүй байх арга хэмжээ авна.

20.3.Шинжилгээний байгууллага, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд нь шинжээчийн талаарх мэдээлэл, шинжилгээний явц, үр дүнг шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас өмнө бусдад задруулахыг хориглоно.

## **21 дүгээр зүйл.Шинжилгээний хураамж, зардал**

21.1.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн<sup>12</sup> 20<sup>1</sup>.1-д заасны дагуу зарим төрлийн шинжилгээ хийхэд улсын тэмдэгтийн хураамж авна.

21.2.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 20<sup>1</sup>.1-д зааснаас бусад шүүх эмнэлгийн шинжилгээний хураамжийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлнэ.

21.3.Энэ хуулийн 21.2-т заасан шүүх эмнэлгийн шинжилгээний төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх боломжгүй Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн урьдчилан төлнө.

21.4.Шинжилгээний байгууллагаас бусад байгууллагад ажиллаж байгаа тусгай мэдлэг бүхий хүнийг шинжээчээр томилон ажиллуулсан тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 53.1.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.3.1, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.11 дүгээр зүйлийн 1.1, 2, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 11.4 дүгээр зүйлийн 1.1, 11.5 дугаар зүйлийн 1, 2-т заасны дагуу шинжээчийн зардлыг төлнө.

<sup>12</sup>Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ШИНЖИЛГЭЭНИЙ АДИЛТГАЛ, МЭДЭЭЛЛИЙН САН,  
ТҮҮНИЙ ТӨРӨЛ, БҮРДҮҮЛЭЛТ, АШИГЛАЛТ,  
ХАМГААЛАЛТ**

**22 дугаар зүйл. Шинжилгээний адилтгал, мэдээллийн сан,  
түүний төрөл**

22.1. Шинжилгээний байгууллага шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад шаардлагатай шинжилгээний адилтгал, мэдээллийн сантай байна.

22.2. Шинжилгээний адилтгал, мэдээллийн сан нь нэгдсэн болон төрөлжсөн сангаас бүрдэнэ.

22.3. Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

- 22.3.1. гарын мөрийн;
- 22.3.2. галт зэвсгийн, хонгио, хошууны;
- 22.3.3. генетик мэдээллийн;
- 22.3.4. үнэлгээний мэдээллийн;
- 22.3.5. экологийн шинжилгээний сан.

22.4. Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн сан дараах мэдээллээс бүрдэнэ:

- 22.4.1. бичиг баримтын;
- 22.4.2. үнэт цаас, мөнгөн дэвсгэртийн;
- 22.4.3. тамга тэмдэг, түүний дардасны;
- 22.4.4. гутлын мөрийн;
- 22.4.5. тээврийн хэрэгслийн мөрийн;
- 22.4.6. нэр, хаяг тодорхойгүй цогцосны мэдээллийн;
- 22.4.7. шүүх дүрс оношилгооны мэдээллийн;
- 22.4.8. бусад.

**23 дугаар зүйл. Шинжилгээний адилтгал, мэдээллийн санг  
хөтлөх, ашиглах**

23.1. Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санг улсын хэмжээнд, төрөлжсөн санг шинжилгээний лабораторид үүсгэж хөтөлнө.

23.2. Шинжилгээний байгууллага энэ хуулийн 22.3, 22.4-т зааснаас бусад төрлийн шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан шинээр үүсгэж болно.



23.3.Шинжилгээний байгууллага шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санг шинэчлэх, санд мэдээлэл цуглуулах, боловсруулах ажлыг төрийн байгууллага, хуулийн этгээдтэй хамтран зохион байгуулна.

23.4.Хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллага төрийн байгууллага, хуулийн этгээдээс шинжилгээний адилтгал, мэдээллийн санд шаардлагатай бүтээгдэхүүний эх хувь, тэдгээрийн мэдээлэл, танилцуулгыг гаргуулан авна.

23.5.Шаардлагатай тохиолдолд шинжилгээний байгууллага зарим төрлийн шинжилгээний объект, харьцуулах загварыг шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санд авч болно.

23.6.Шинжилгээний байгууллага шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн санг шинжилгээ хийж, дүгнэлт гаргах, эсхүл эрх бүхий байгууллагад лавлагаа мэдээлэл өгөх зорилгоор ашиглана.

23.7.Шинжилгээний адилтгал, мэдээллийн төрөлжсөн санг шинжилгээний байгууллага шинжилгээ хийхэд ашиглана.

23.8.Шинжилгээний байгууллага энэ хуулийн 23.6, 23.7-д зааснаас бусад зорилгоор шинжилгээний адилтгал, мэдээллийн санг ашиглахыг хориглоно.

23.9.Хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа бусад байгууллагын мэдээллийн санг ашиглаж болно.

#### **24 дүгээр зүйл. Шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн аюулгүй байдал**

24.1.Шинжилгээний байгууллага шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангана.

24.2.Шинжилгээний байгууллагын шинжээч болон бусад алба хаагч шинжилгээний байгууллагын шинжилгээний адилтгал, мэдээллийн санг бусад этгээдэд шилжүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашиглахыг хориглоно.

24.3.Шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн мэдээллийг ашиглаж байгаа этгээд тухайн мэдээлэлтэй холбоотой хуулиар хамгаалагдсан нууцлалыг хадгалах үүрэгтэй.

24.4.Шинжилгээний адилтгал, мэдээллийн санг хуулиар хүлээсэн чиг үүрэгтээ хамааралгүй зорилгоор ашигласан, бусдад шилжүүлсэн, шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн нууцлалыг задруулсан бол буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

24.5.Шинжилгээний адилтгал, мэдээллийн сангийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах хүрээнд шинжилгээний байгууллага шаардлагатай программ хангамж, техник хэрэгслээр хангагдсан байна.

24.6.Шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн санг хөтлөх, мэдээлэл цуглуулах, боловсруулах, ашиглах, хамгаалах, нууцлалын аюулгүй байдлыг хангах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛБЭР**

### **25 дугаар зүйл.Шинжилгээний хэлбэр**

25.1.Шинжилгээ нь анхдагч, нэмэлт, дахин гэсэн хэлбэртэй байна.

### **26 дугаар зүйл.Анхдагч шинжилгээ хийх**

26.1.Шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд анхдагч шинжилгээг нэг, түүнээс дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийлгэж болно.

26.2.Анхдагч шинжилгээг багаар хийлгэх багийн бүрэлдэхүүнд шинжилгээний байгууллагын шинжээчээс гадна тухайн байгууллагад ажилладаггүй тусгай мэдлэг бүхий хүнийг оролцуулж болно.

### **27 дугаар зүйл.Нэмэлт шинжилгээ хийх**

27.1.Шинжээчийн дүгнэлт бүрэн бус, эсхүл шинжилгээ хийлгэж байгаа асуудалтай холбоотой шинэ нөхцөл байдал бий болсон тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр нэмэлт шинжилгээ хийнэ.

27.2.Нэмэлт шинжилгээг анхдагч шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан болон гаргахад оролцсон шинжээчээр хийлгэж болно.

27.3.Нэмэлт шинжилгээ хийх хугацааг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан журмын дагуу тогтооно.

### **28 дугаар зүйл. Дахин шинжилгээ хийх**

28.1. Шинжээчийн дүгнэлт, түүний зарим хэсэг үндэслэлгүй, эсхүл үндэслэлтэй эсэх нь эргэлзээтэй байвал шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр дахин шинжилгээ хийнэ.

28.2. Дахин шинжилгээ хийхэд анхдагч, эсхүл нэмэлт шинжилгээ хийж, дүгнэлт гаргасан шинжээчийг оролцуулахыг хориглоно.

28.3. Дахин шинжилгээ хийх хугацааг энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан журмын дагуу тогтооно.

28.4. Дахин шинжилгээ хийхэд анхдагч болон нэмэлт шинжилгээнд ирүүлсэн шинжилгээний объектыг бусад холбогдох материалын хамт ирүүлнэ.

28.5. Дахин шинжилгээний үр дүн анхдагч, нэмэлт шинжилгээний үр дүнтэй адил бол дахин шинжилгээ хийхгүй.

### **29 дүгээр зүйл. Шинжилгээг шинжээчдийн багаар хийх**

29.1. Шаардлагатай тохиолдолд шинжилгээг ижил, эсхүл өөр өөр мэргэжлийн шинжээчийн бүрэлдэхүүнтэй багаар хийлгэж болно.

29.2. Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд шинжилгээний байгууллагын шинжээчээс гадна энэ хуулийн 8.2.1, 8.2.2, 8.2.3-т заасан этгээдийг оролцуулах бол хамтран ажиллах нөхцөлийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд, эсхүл шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах нэгжийн дарга тодорхойлно. Бусад этгээдтэй хамтран ажиллах журмыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.

29.3. Энэ хуулийн 29.2-т заасан тохиолдолд шинжилгээний байгууллага энэ талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

29.4. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан шинжилгээ хийлгэх шийдвэр, шинжилгээний объектыг хүлээн авч, шинжилгээний цар хүрээ, нарийн төвөгтэй байдал зэргийг харгалзан шинжилгээг шинжээчдийн багаар хийлгэх эсэхийг шийдвэрлэнэ.



### **30 дугаар зүйл.Шинжилгээг ижил мэргэжлийн шинжээчдийн багаар хийх**

30.1.Ижил мэргэжлийн шинжээчдийн баг 2, түүнээс дээш шинжээчийн бүрэлдэхүүнтэй байна.

30.2.Шинжилгээг ижил мэргэжлийн шинжээчдийн баг хийх явцад шинжээч тус бүр шинжилгээг эхнээс нь дуустал бие дааж хийх бөгөөд үр дүнгээ нэгтгэн дүгнэлт гаргана.

30.3.Шинжээчид харилцан зөвшилцсөний үндсэн дээр шинжилгээ хийх дэс дараалал, цар хүрээ, арга зүйг тогтооно.

30.4.Шинжээчид шинжилгээний үр дүнгийн талаар нэгдсэн саналд хүрсэн бол нэг дүгнэлт гаргах бөгөөд санал зөрсөн тохиолдолд санал зөрсөн шинжээч саналаа дүгнэлтэд хавсаргана.

### **31 дүгээр зүйл.Шинжилгээг өөр өөр мэргэжлийн шинжээчдийн багаар хийх**

31.1.Шинжилгээг өөр өөр мэргэжлийн шинжээчдийн баг хийх явцад шинжээч тус бүр өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд шинжилгээ хийнэ.

31.2.Шинжээчийн дүгнэлтэд шинжээч тус бүрийн хийсэн шинжилгээний төрөл, агуулга, гаргасан дүгнэлтийг тусгана.

31.3.Шинжилгээнд оролцсон шинжээч тус бүр зөвхөн өөрийн хийсэн шинжилгээг тусгасан дүгнэлтийн хэсэгт гарын үсэг зурж, дүгнэлтийн үндэслэлээ хариуцна.

31.4.Шинжилгээний явцад шинжээчид ижил дүгнэлтэд хүрсэн бол энэ тухай дүгнэлтэд тэмдэглэнэ.

31.5.Шинжээчид санал зөрсөн тохиолдолд энэ хуулийн 30.4-т заасны дагуу дүгнэлт гаргана.

### **ТАВДУГААР БҮЛЭГ ЗАРИМ ШИНЖИЛГЭЭНИЙ ОНЦЛОГ**

### **32 дугаар зүйл.Криминалистикийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

32.1.Шинжилгээнд шаардлагатай баримт материалыг эх хувиар, эсхүл энэ хуулийн 12.3.2-т заасан шаардлага хангахуйц байдлаар ирүүлнэ.

32.2.Эд мөрийн баримт дээрх ул мөрийг устаж гэмтэхээргүй байдлаар энэ хуулийн 13.1-д заасан шаардлагын дагуу тус тусад нь савлаж, битүүмжлэн шинжилгээнд ирүүлнэ.

32.3.Тэсэрч дэлбэрэх бодис, сум, галт хэрэгсэл, цөмийн бодис, материал, цацраг идэвхт үүсгүүр болон хаягдал, хими, биологийн болон аюул учруулж болзошгүй бусад объектод зориулалтын төхөөрөмжөөр тоноглож аюулгүй байдлыг хангасан орчинд тогтоосон журмын дагуу шинжилгээ хийнэ.

32.4.Криминалистикийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **33 дугаар зүйл. Шүүх эмнэлгийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

33.1.Шүүх эмнэлгийн шинжилгээг дараах тохиолдолд хийнэ:

33.1.1.гадны нөлөөгөөр, эсхүл сэжигтэй байдлаар хүн нас барсан бол түүний шалтгааныг тогтоох;

33.1.2.хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох;

33.1.3.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн шийдвэрээр хүний нас, түүнчлэн цогцос нь хэдэн настай хүн байсныг тогтоох;

33.1.4.ялтан ял эдэлж байх хугацаандаа ялаас чөлөөлөх өвчний жагсаалтад багтсан өвчнөөр өвдөж, ял эдлэх боломжгүй болсон тохиолдолд эрүүл мэндийн байдлыг тогтоох.

33.2.Хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэргийг хүний биед хийх шүүх эмнэлгийн шинжилгээ болон хэргийн материалд хийх шүүх эмнэлгийн шинжилгээгээр тогтооно.

33.3.Хэргийн материалд хийх шүүх эмнэлгийн шинжилгээний объект болох эмнэлгийн баримт бичиг нь баталгаажсан эх хувь байна.

33.4.Цар тахал, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, цацраг туяа, химийн хорт болон аюултай бодисын улмаас нас барсан нь бусад нотлох баримтаар тогтоогдсон бол прокурорын зөвшөөрлөөр цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийхгүй.

33.5.Цогцост шүүх дүрс оношилгооны шинжилгээ хийсэн тохиолдолд үр дүн нь шинжээчийн дүгнэлт гаргахад хангалттай бол цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийхгүй байж болно.



33.6.Цогцост хийх шүүх эмнэлгийн задлан шинжилгээг боломжит нөхцөлд тохируулан хийж болно.

33.7.Цогцост үзлэг, шинжилгээ хийх явцыг гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэн авах зэрэг үйл ажиллагаанд хүндэтгэлтэй хандана.

33.8.Цогцост шүүх эмнэлгийн задлан шинжилгээ хийх явцад шинжилгээний болон эрдэм шинжилгээ, судалгаа, сургалтын зорилгоор эд, эрхтнээс дээж авсан бол энэ талаар шинжилгээний тэмдэглэлд тодорхой тусгана.

33.9.Шүүх эмнэлгийн шинжилгээ хийх журам, хүний эрүүл мэндэд учирсан хохирлын зэрэг тогтоох журмыг эрүүл мэнд болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурортой хамтран батална.

#### **34 дүгээр зүйл.Эдийн засгийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

34.1.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд эдийн засгийн шинжилгээ хийнэ:

34.1.1.эрх бүхий байгууллагаас гаргасан акт, дүгнэлт, тусгай мэдлэг бүхий мөрдөгчийн магадалгаа нь тухайн хэргийг шийдвэрлэхэд хангалттай үндэслэл болж чадахгүй байгаа;

34.1.2.эрх бүхий байгууллагаас гаргасан акт, дүгнэлт үнэн зөв, бодитой эсэх нь эргэлзээтэй, эсхүл үнэн зөв бодитой тодорхойлж чадаагүй нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад илэрсэн;

34.1.3.эрх бүхий байгууллагын гаргасан акт, дүгнэлт нь буруу гэдгийг холбогдох этгээд тодорхой баримтаар нотолсон;

34.1.4.хуульд заасан бусад тохиолдолд.

34.2.Эдийн засгийн шинжилгээний объект нь нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримтын шаардлага хангасан баримт бичиг байна.

34.3.Эдийн засгийн шинжилгээ хийж байгаа шинжээч нь энэ хуулийн 34.1.1-д заасан эрх бүхий байгууллагын гаргасан акт, дүгнэлтэд эргэлзээ төрвөл баримтын шалгалтыг дахин хийлгэх, эсхүл тооллого

явуулах талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд хүсэлт гаргаж болно.

34.4.Эдийн засгийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

Тайлбар: -Энэ хуулийн 34.1.1-д заасан эрх бүхий байгууллага гэдэгт аудитын байгууллага, гааль, татвар, санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлэгч эрх бүхий байгууллага, төрийн байгууллагын дотоод аудитын нэгж, тухайн салбараас эрх олгогдсон мэргэжлийн байгууллага орно.

### **35 дугаар зүйл.Хөрөнгийн үнэлгээний шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

35.1.Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийхэд хөрөнгийн үнэлгээний тайлан гарсан байна.

35.2.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд хөрөнгийн үнэлгээний шинжилгээг шинжилгээний байгууллага хийнэ:

35.2.1.мэргэжлийн байгууллагын хөрөнгийн үнэлгээчин хөрөнгийн үнэлгээний суурийг тодорхойлохдоо тухайн зүйлийн шинж байдал, онцлогт үндэслээгүй;

35.2.2.хөрөнгийн үнэлгээ хийх явцад хөрөнгийн үнэлгээний стандарт, дүрэм, журам, норм, нормативыг зөрчсөн;

35.2.3.хөрөнгийн үнэлгээний зүйлийн тогтоосон үнэ цэнэ үндэслэлгүй, бодитой бус, тодорхой бус байх;

35.2.4.хуульд заасан бусад тохиолдолд.

35.3.Хөрөнгийн үнэлгээний шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

### **36 дугаар зүйл.Цахим технологийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

36.1.Төхөөрөмжийг биет байдлаар зөөвөрлөн ирүүлэх боломжгүй бол цахим мэдээллийг тусгай программ ашиглан хуулбарлан авч засварлаж, өөрчлөх боломжгүйгээр код үүсгэн шинжилгээнд ирүүлнэ.

36.2.Энэ хуулийн 36.1-д заасан шинжилгээ хийх боломжгүй тохиолдолд түүний эх хувийг агуулж байгаа хадгалах төхөөрөмжид шинжилгээ хийнэ.

36.3.Шаардлагатай тохиолдолд шинжээч цахим технологийн шинжилгээнд гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний харьцуулах загвар авч болно.

36.4.Цахим технологийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

### **37 дугаар зүйл.Инженер-техникийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

37.1.Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад инженерийн байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүнд чанарын болон тоон, технологийн өөрчлөлт байгаа эсэх, үүссэн нөхцөл байдлын шалтгааныг тогтоох зорилгоор шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

37.2.Инженер-техникийн шинжилгээнд шинжилгээний объект нь үл хөдлөх хөрөнгө, эсхүл овор хэмжээ их, зөөвөрлөх боломжгүй тохиолдолд шинжилгээг тухайн объектын оршин байгаа газарт хийнэ.

37.3.Энэ хуулийн 37.2-т зааснаас бусад тохиолдолд шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад хүргүүлнэ.

37.4.Инженер-техникийн шинжилгээний объектыг шинжилгээний байгууллагад ирүүлсэн тохиолдолд шинжилгээг зориулалтын тоног төхөөрөмжтэй лабораторид хийнэ.

37.5.Шаардлагатай тохиолдолд шинжилгээний байгууллага инженер-техникийн шинжилгээний объектыг мэргэжлийн байгууллагын лабораторид илгээж, гарсан үр дүнг үнэлж, дүгнэлт гаргаж болно.

37.6.Мэргэжлийн байгууллагын лабораторид хийгдсэн шинжилгээний зардлыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд хариуцан шийдвэрлэнэ.

37.7.Инженер-техникийн шинжилгээ хийх журмыг холбогдох асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

### **38 дугаар зүйл. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

38.1. Шинжилгээний байгууллага энэ хуульд зааснаас бусад тохиолдолд эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрайн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд шинжилгээ хийлгэх шийдвэрээр хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн тус бүрээр хийнэ:

38.1.1. иргэн, хуулийн этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас хүрээлэн байгаа орчинд хохирол учирсан;

38.1.2. байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, нарийвчилсан үнэлгээний тайлан, эсхүл нарийвчилсан үнэлгээний тайланд хийгдсэн Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн<sup>13</sup> 3.1.9-д заасан хянан магадалгаа буруу хийгдсэн нь хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад илэрсэн;

38.1.3. байгаль орчны нөлөөллийн ерөнхий, эсхүл нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж байгаа, эсхүл учруулсан.

38.2. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг шинжээчдийн баг хийнэ.

38.3. Шинжилгээний байгууллага хүрээлэн байгаа орчны хохирлыг хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн тус бүрээр нь тооцохдоо нөхөн сэргээх зардлыг давхар тооцно.

38.4. Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээг хийхдээ энэ хуульд заасан шинжилгээний нийтлэг журмыг баримтлан байгаль орчны хууль тогтоомж, түүнийг дагаж гарсан эрх зүйн актыг дагаж мөрдөнө.

38.5. Эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрайн хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах нөхцөл байдал илэрсэн тохиолдолд байгаль орчны нөлөөллийн үнэлгээний шинжилгээг шинжилгээний байгууллага хийнэ:

<sup>13</sup> Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 22 дугаарт нийтлэгдсэн.



38.5.1.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, эсхүл нарийвчилсан үнэлгээний тайлан, эсхүл түүнд хийгдсэн хянан магадалгаа нь үнэн зөв эсэх нь эргэлзээтэй, эсхүл хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдсон;

38.5.2.байгаль орчны нөлөөллийн ерөнхий, эсхүл нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол ерөнхий үнэлгээний дүгнэлт, эсхүл нарийвчилсан үнэлгээний дүгнэлт үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох;

38.5.3.хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт нь эргэлзээтэй бол байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээний дүгнэлт, эсхүл нарийвчилсан үнэлгээний дүгнэлт үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох;

38.5.4.хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээний тайлан, дүгнэлт эргэлзээтэй бол уг тайлан, дүгнэлт нь үнэн зөв хийгдсэн эсэхийг тогтоолгох.

38.6.Хүрээлэн байгаа орчинд хохирол учруулсан шинжилгээний материал нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлт гарсан, эсхүл хянан магадалгаа хийгдсэн байна.

38.7.Шинжилгээний байгууллага шаардлагатай тохиолдолд хүрээлэн байгаа орчны шинжилгээний объектыг мэргэжлийн байгууллагын лабораторид илгээж, гарсан үр дүнг үнэлэн дүгнэлт гаргаж болно.

38.8.Мэргэжлийн байгууллагын лабораторид хийгдсэн шинжилгээний зардлыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд холбогдох хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэнэ.

38.9.Энэ хуулийн 38.8-д заасан зардлыг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн<sup>14</sup> 7.3.5-д заасны дагуу Байгаль орчин, уур амьсгалын сангаас санхүүжүүлж болно.

38.10.Хүрээлэн байгаа орчны хохирлын үнэлгээ, шинжилгээ хийх журмыг хууль болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

<sup>14</sup>Засгийн газрын тусгай сангийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2019 оны 48 дугаарт нийтлэгдсэн.



Тайлбар: -Энэ хуулийн 38.1-д заасан хүрээлэн байгаа орчны бүрэлдэхүүн хэсэг гэж агаар, ус, хөрс, газар, түүний хэвлий, амьтан, ургамал, ойг ойлгоно.

### **39 дүгээр зүйл.Сэтгэцийн шинжилгээнд тавигдах тусгай шаардлага**

39.1.Сэтгэцийн шинжилгээг дараах тохиолдолд хийнэ:

39.1.1.эрүүгийн хэргийн гэрч, хохирогч, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитой тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ төрвөл түүний сэтгэцийн байдлыг тодорхойлоход;

39.1.2.бүх насаар хорих ял оногдуулж болох гэмт хэргийн яллагдагчийн сэтгэцийн байдлыг тодорхойлоход;

39.1.3.иргэний, захиргааны, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгч, хариуцагч иргэн нь иргэний эрх зүйн чадамжтай эсэхэд эргэлзээ байвал тэдний сэтгэцийн байдлыг тодорхойлоход;

39.1.4.иргэний, захиргааны, арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч хэрэгт ач холбогдол бүхий байдлыг бодитойгоор тусгаж, зөв мэдүүлэг өгөх чадвартай эсэхэд эргэлзээ байвал түүний сэтгэцийн байдлыг тодорхойлоход;

39.1.5.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.11 дүгээр зүйлийн 2.1, 2.2-т заасан нөхцөлд;

39.1.6.гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн хувьд эрүүл байсан боловч шийтгэх тогтоол гаргахын өмнө сэтгэцийн өвчнөөр өвчилсөн, эсхүл урьд нь сэтгэцийн өвчтэй, хэрэг хариуцах чадваргүй гэж тогтоогдсон этгээдэд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтооход;

39.1.7.ял эдэлж байх үедээ сэтгэцийн өвчнөөр өвчилсөн ялтанд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авах шаардлагатай эсэхийг тогтооход;

39.1.8.энэ хуулийн 40.1-д заасан сэтгэцэд учирсан хор уршиг;

39.1.9.хуульд заасан бусад тохиолдолд.

39.2.Шинжээч сэтгэцийн шинжилгээ хийж, дүгнэлт гаргахдаа сэтгэцийн үзлэг, шинжилгээний дүн материалаас гадна урьд нь тухайн этгээдийн эмчлүүлж, эмчилгээ хийлгэж байсан эмнэлгийн баримт бичгийг үндэслэж болно.

39.3.Сэтгэцийн шинжилгээ хийлгэх шаардлагатай цагдан хоригдоогүй яллагдагч, шүүгдэгчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байрлуулж шинжилгээ хийнэ.

39.4.Энэ хуулийн 39.3-т заасны дагуу шинжилгээ хийлгэж байгаа яллагдагч, шүүгдэгч хүний амь нас, эрүүл мэндийг хохироох, эмнэлгийн үйл ажиллагаанд саад учруулж болзошгүй үйлдэл хийсэн бол цагдаагийн байгууллагад мэдэгдэж, үйлдлийг нь таслан зогсоох арга хэмжээ авна.

39.5.Өөрийн хүсэлтээр шинжилгээ хийлгэж байгаа яллагдагч, шүүгдэгч энэ хуулийн 39.4-т заасан үйлдлийг хийсэн бол уг этгээдийг эмнэлгийн захиргаа эмнэлгээс гаргаж, энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

39.6.Цагдан хоригдож байгаа этгээдэд хийх сэтгэцийн шинжилгээг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт хийх бөгөөд эмнэлгийн аюулгүй байдал, хамгаалалтыг цагдан хорих байрны аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллага хариуцна.

39.7.Гэрч, хохирогчийг сэтгэцийн эмгэг судлалын эмнэлэгт байршуулж, сэтгэцийн шинжилгээ хийх боломжгүй хүндээр өвчилсөн, гэмтсэн тохиолдолд шинжээч, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн хамт тухайн этгээдийн байгаа газарт очиж шинжилгээ хийж болно.

39.8.Сэтгэцийн шинжилгээ хийх журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **40 дүгээр зүйл.Сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоох үнэлгээ**

40.1.Шинжилгээний байгууллага Эрүүгийн хуулийн Аравдугаар бүлэг/Хүний амьд явах эрхийн эсрэг/, Арван нэгдүгээр бүлэг/Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг/, Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг/, Арван гуравдугаар бүлэг/Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийн эсрэг/, 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадурхах/, 14.2 дугаар зүйл /Мэдээлэл хайх, хүлээн авахад саад учруулах/, 14.3 дугаар зүйл /Үзэл бодлоо илэрхийлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөнд халдах/, 14.4 дүгээр зүйл /Шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөг хэрэгжүүлэхэд саад учруулах/, 14.8 дугаар зүйл /Сонгуулийн үеэр илт худал

мэдээлэл тараах/, Арван тавдугаар бүлэг/Эрүүл мэндийн эсрэг/, Арван зургадугаар бүлэг/Хүүхдийн эсрэг/, 17.1 дүгээр зүйл /Хулгайлах/, 17.2 дугаар зүйл /Дээрэмдэх/, 17.3 дугаар зүйл /Залилах/, 17.6 дугаар зүйл /Бусдын эд хөрөнгийг авахаар заналхийлэх/, 17.8 дугаар зүйл /Эд хөрөнгө устгах, гэмтээх/, 17.10 дугаар зүйл /Нотариатч, улсын бүртгэгч өмчлөгчийн эрхийг зөрчих/, 17.12 дугаар зүйл /Мал хулгайлах/, 20.11 дүгээр зүйл /Аюултай хог хаягдал, химийн хорт, аюултай бодисыг хаях/, 20.12 дугаар зүйл /Эрүүл ахуйн шаардлага хангаагүй хүнсний бүтээгдэхүүн худалдах, түгээх/, 20.13 дугаар зүйл /Чанар муутай барилга байгууламж ашиглалтад оруулах/, 20.14 дүгээр зүйл /Хууль бусаар эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл үйлдвэрлэх, импортлох, худалдах, түгээх/, 20.16 дугаар зүйл /Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах/, 21.5 дугаар зүйл /Гэрч, хохирогч, шинжээч, орчуулагч, хэлмэрчид хууль бусаар нөлөөлөх/, 21.12 дугаар зүйл /Эрүү шүүлт тулгах/, 21.13 дугаар зүйл /Гүйцэтгэх ажлын тухай хууль зөрчих/, 24.1 дүгээр зүйл /Байгаль орчныг бохирдуулах/, 24.3 дугаар зүйл /Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах/, 24.7 дугаар зүйл /Ой, хээрийн түймэр тавих/, 27.3 дугаар зүйл /Төмөр замын, агаарын, усан замын тээврийн хөдөлгөөний ба ашиглалтын аюулгүй байдлын журам зөрчих/, 27.7 дугаар зүйл /Агаарын хөдөлгөөний аюулгүй байдалд халдах/, 27.8 дугаар зүйл /Агаарын хөлгийг авч зугтаах/, 27.10 дугаар зүйл /Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих/, 28.3 дугаар зүйл /Дарга, захирагч нь захирагдагчдаа хүч хэрэглэх/, 28.4 дүгээр зүйл /Бие биедээ захирагдахгүй цэргийн алба хаагчид харилцахдаа дүрмийн заалт зөрчих/, 28.10 дугаар зүйл /Байлдааны машин жолоодох, ашиглалтын журам зөрчих/, 28.11 дүгээр зүйл /Байлдааны, сургуулийн нислэг хийх, түүнд бэлтгэх журам зөрчих/, 29.4 дүгээр зүйл /Дайны үед хориглосон арга, хэрэгсэл хэрэглэх/, 29.5 дугаар зүйл /Төрлөөр устгах/, 29.7 дугаар зүйл /Олон улсын хамгаалалтад байдаг хүнд халдах/, 29.8 дугаар зүйл /Террорист үйлдэл хийх/-д заасан гэмт хэргийн улмаас хүний сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож, дүгнэлт гаргана.

40.2.Шинжилгээний байгууллага сэтгэцэд учирсан хор уршгийн зэрэглэлийг тогтоож дүгнэлт гаргахдаа дараах нөхцөлийг харгалзан үзнэ:

40.2.1.хохирогч нь энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн хохирогч байх, эсхүл хохирогч нас барсан бол хохирогчийн гэр бүлийн гишүүн байх;

40.2.2.энэ хуулийн 40.1-д заасан гэмт хэргийн улмаас хохирогчийн сэтгэцэд түр зуурын, эсхүл байнгын шинжтэй өөрчлөлт орсон байх;

40.2.3.хохирогчийн сэтгэцэд учирсан хямрал, эмгэгийг сэтгэцийн шинжилгээгээр тогтоосон байх.



40.3.Энэ хуулийн 40.1-д заасан дүгнэлт гаргах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ ХҮНИЙ БИЕД ШИНЖИЛГЭЭ ХИЙХ**

### **41 дүгээр зүйл.Хүний биед шинжилгээ хийх үндэслэл**

41.1.Эрүүгийн, иргэний, захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад хүний биед шинжилгээ хийж болно.

41.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 27.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр, эсхүл иргэний, захиргааны хэрэг, маргаан хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад хүний биед шинжилгээ хийлгэх шаардлагатай гэж үзвэл энэ хуулийн 4.1.7-д заасан этгээд шинжилгээ хийлгэх шийдвэр гаргана.

### **42 дугаар зүйл.Хүний биед шинжилгээ хийх нөхцөл**

42.1.Хүний биед хийх шинжилгээг шинжилгээ хийх болон шинжилгээ хийлгэх этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хангасан орчин, нөхцөлд хийнэ.

42.2.Хүний биед хийх шинжилгээг шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллага, албадан саатуулах, баривчлах, цагдан хорих байр, хорих ангид болон зайлшгүй тохиолдолд боломжит нөхцөлд хийж болно.

42.3.Шинжилгээ хийлгэх этгээд нь шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад хүрэлцэн ирэх боломжгүй хүндээр өвчилсөн, гэмтсэн тохиолдолд шинжээч, шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн хамт тухайн этгээдийн байгаа газарт очиж шинжилгээ хийж болно.

42.4.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулан шинжилгээ хийж болно.

42.5.Шинжилгээ хийлгэх этгээдийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний болон эрүүл мэндийн байгууллагад хүргэнэ.

42.6.Шинжилгээ хийлгэх этгээд нь 18 насанд хүрээгүй, эсхүл 18 насанд хүрсэн боловч эрх зүйн чадамжгүй нь тогтоогдсон бол түүний хууль ёсны төлөөлөгчийг байлцуулна.

42.7.Энэ хуулийн 42.6-д заасан хууль ёсны төлөөлөгчөөр тогтоогдвол зохих хүн байхгүй, эсхүл ашиг сонирхлын зөрчилтэй бол хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын ажилтан, эсхүл тухайн оршин суугаа газрын харьяалах нийгмийн ажилтныг төлөөлөгчөөр оролцуулан шинжилгээ хийхэд байлцуулна.

#### **43 дугаар зүйл.Шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах үндэслэл, журам**

43.1.Сэтгэцийн шинжилгээний дүгнэлт гаргахын тулд шинжилгээ хийлгэх этгээдийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 19.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан үндэслэл, журмын дагуу эрүүл мэндийн байгууллагад байрлуулж болно.

43.2.Энэ хуулийн 43.1-д заасан үндэслэлээр яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулсан бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд 24 цагийн дотор түүний гэр бүлийн насанд хүрсэн гишүүн, төрөл, садангийн хүн, хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчид нь мэдэгдэх бөгөөд энэ тухай шинжилгээ хийлгэх шийдвэрт тэмдэглэнэ.

43.3.Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журмыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

#### **44 дүгээр зүйл.Шинжилгээ хийлгэх этгээдийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацаа**

44.1.Шинжилгээ хийж, дүгнэлт гаргахын тулд яллагдагч, шүүгдэгчийг энэ хуулийн 16.1-д заасан хугацаагаар эрүүл мэндийн байгууллагад байрлуулна.

44.2.Шаардлагатай тохиолдолд шинжээчийн үндэслэл бүхий хүсэлтийг үндэслэн яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг энэ хуулийн 16.1-д заасан жишиг хугацаагаар сунгаж болно.

44.3.Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг сунгахдаа энэ хуулийн 16.4-т заасан журмын дагуу шийдвэрлэж, энэ талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэнэ.

44.4.Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах хугацааг сунгахаас татгалзсан бол шинжилгээ хийлгэх этгээдийг даруй эмнэлгээс гаргана.

#### **45 дугаар зүйл. Яллагдагч, шүүгдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах**

45.1. Яллагдагч, шүүгдэгчийн биед шинжилгээ хийхэд дараах ажиллагаа явуулахыг хориглоно:

45.1.1. яллагдагч, шүүгдэгчээс мэдээлэл авах зорилгоор эрхийг нь хязгаарлах, хуурч мэхлэх, хүч хэрэглэх, айлган сүрдүүлэх болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.14 дүгээр зүйлийн 4-т заасан хууль бус арга хэрэглэн шинжилгээ хийх;

45.1.2. яллагдагч, шүүгдэгчийн биед шинэ эм, эмчилгээ, түүнчлэн оношилгооны болон өвчнөөс урьдчилан сэргийлэх шинэ арга хэрэгсэл турших, эмнэлгийн туршилтын шинжилгээ хийх;

45.1.3. яллагдагч, шүүгдэгчийг урьд нь эмчилж байсан эмчийг шинжилгээнд оролцуулах;

45.1.4. шинжилгээний явцад олж мэдсэн, шинжилгээний объектод хамаарахгүй асуудлаар мэдүүлэг өгөхийг шинжээчээс шаардах;

45.1.5. эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэх.

45.2. Яллагдагч, шүүгдэгч шинжилж байгаа зүйлийн талаар шинжээчид тайлбар өгөх эрхтэй.

45.3. Шаардлагатай тохиолдолд шинжилгээ хийлгэж байгаа яллагдагч, шүүгдэгчид Эрүүл мэндийн тухай хуульд<sup>15</sup> заасны дагуу эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ.

#### **46 дугаар зүйл. Хүний биед хийх шинжилгээний аргад тавих хязгаарлалт**

46.1. Хүний биед шинжилгээ хийхдээ эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хэрэглэгдээгүй болон хэрэглэхийг хориглосон эм тариа, арга хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

46.2. Шинжээч шинжилгээний арга, үүсэж болзошгүй өвдөлт, сөрөг нөлөөний тухай шинжилгээ хийлгэж байгаа хүнд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

<sup>15</sup> Эрүүл мэндийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

46.3.Шинжилгээний хэв загвар, дээжийг шинжилгээ хийлгэж байгаа хүнээс эмнэлгийн байгууллагад авч энэ тухай шинжээчийн дүгнэлтэд тусгаж, тухайн хүнд болон түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ.

46.4.Шинжилгээний хэв загвар, дээж авахад хөндлөнгийн 2 гэрч байлцуулна.

#### **47 дугаар зүйл.Хүний биед хийх шинжилгээний явцад хэргийн оролцогчийг байлцуулах**

47.1.Хүний биед шинжилгээ хийх явцад шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон яллагдагч, шүүгдэгчийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн зөвшөөрснөөр хэргийн бусад оролцогчийг байлцуулж болно.

47.2.Яллагдагч, шүүгдэгчийг нүцгэлэх шаардлагатай бол зөвхөн түүнтэй ижил хүйсийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогчийг байлцуулж болох бөгөөд энэ хязгаарлалт нь шинжилгээ хийхэд оролцож байгаа эмч, эмнэлгийн мэргэжилтэнд хамаарахгүй.

#### **ДОЛДУГААР БҮЛЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ ОРОЛЦОГЧ**

#### **48 дугаар зүйл.Шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтны эрх, үүрэг, хориглох зүйл**

48.1.Шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан нь дараах эрх эдэлнэ:

48.1.1.тухайн байгууллагад зохих чиглэлээр тусгай мэдлэг бүхий шинжээч, шаардлагатай техник хэрэгсэл, шинжилгээ хийх шаардлага хангасан нөхцөл бүрдээгүй бол шалтгааныг зааж шинжилгээний объект болон шинжилгээ хийлгэх шийдвэрийг буцаах;

48.1.2.шаардлагатай тусгай мэдлэг бүхий тухайн байгууллагад ажилладаггүй хүнийг шинжээчдийн багт оруулах саналыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргах;

48.1.3.шинжээчид шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах үүргийг шинжилгээний байгууллагын эрх бүхий бусад этгээдэд шилжүүлэх;

48.1.4.шаардлагатай тохиолдолд шинжилгээний хугацааг сунгаж энэ тухай шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэх;



48.1.5.хуульд заасан бусад эрх.

48.2.Шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтан дараах үүрэг хүлээнэ:

48.2.1.шинжилгээний хуваарилалтыг энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасны дагуу гүйцэтгэх;

48.2.2.шинжилгээний хугацаа, шинжилгээ хийх үйл ажиллагааны стандарт, шинжээчийн хараат бус байдлыг хангах;

48.2.3.шинжилгээ хийхэд шаардлагатай нөхцөл бүрдүүлэх;

48.2.4.шинжилгээний явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийг задруулахгүй байх;

48.2.5.шаардлагатай тохиолдолд шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон шинжилгээний явц, шинжээчийн талаарх мэдээллийг нууцалж, аюулгүй байдлыг хангах;

48.2.6.шинжилгээ хийлгэх шийдвэр, хүсэлтэд заасан бусад байгууллага, шинжээчтэй хамтарсан шинжилгээ хийх ажлыг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдтэй хамтран зохион байгуулах;

48.2.7.шинжээч хуульд заасан үндэслэлээр шинжилгээ хийхээс татгалзсан бол шинжилгээг өөр шинжээчид шилжүүлэх;

48.2.8.шинжилгээ хийж дууссаны дараа шинжээчийн дүгнэлтийн үндсэн агуулгад нөлөөлөхгүйгээр шинжилгээ хийх шинжээчид тавьсан асуултад бүрэн хариулсан эсэх, дүгнэлтийн бүтэц, дүгнэлтийг бичсэн дэс дараалал, гэрэл зургийн үзүүлэлтийн чанар зэрэгтэй танилцаж, дүгнэлтийг байгууллагын тэмдгээр баталгаажуулах;

48.2.9.шинжилгээ хийх явцад өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд шинжээч болон шинжээчдийн багт шинжилгээ хийх техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах, шинжээчийн дүгнэлтийн агуулгад нөлөөлөхгүйгээр мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх;

48.2.10.хуульд заасан бусад үүрэг.

48.3.Шинжилгээний байгууллагын шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:

48.3.1.шинжилгээ хийлгэх шийдвэргүй шинжилгээ хийлгэх;  
48.3.2.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд мэдэгдэлгүйгээр бие даан шинжилгээ хийх эрх бүхий бусад этгээдийг шинжилгээнд татан оролцуулах;

48.3.3.шинжээчийн шинжилгээтэй холбоотой үйл ажиллагааг чиглүүлэх, шинжээчийн дүгнэлтийн агуулгад нөлөөлөх;

48.3.4.шинжээчийн хараат бус байдалд нөлөөлөх;

48.3.5.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдэд шинжилгээний үр дүнг мэдээлэх;

48.3.6.хуульд заасан бусад.

#### **49 дүгээр зүйл.Шинжээчийн эрх, үүрэг, хориглох зүйл**

49.1.Шинжээч дараах эрх эдэлнэ:

49.1.1.энэ хуулийн 19 дүгээр зүйлд заасан үндэслэлээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;

49.1.2.шинжилгээ хийхэд шаардлагатай баримт материалтай танилцах;

49.1.3.шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад шаардлагатай, нэмэлт баримт материал ирүүлэхийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс шаардах, ижил, эсхүл өөр мэргэжлийн шинжээчийг татан оролцуулах хүсэлт гаргах;

49.1.4.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд хүсэлт гаргаж, зөвшөөрөл авсны үндсэн дээр мөрдөн шалгах ажиллагаанд оролцох;

49.1.5.дүгнэлт гаргахад ач холбогдол бүхий нөхцөл байдлын талаар шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн зөвшөөрснөөр шинжилгээ хийхтэй холбоотой асуудлаар хэргийн оролцогчид асуулт тавих;

49.1.6.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд энэ хуульд заасан шинжээчийн эрхийг зөрчсөн бол хуульд заасан журмын дагуу гомдол гаргах;

49.1.7.өөрийн тусгай мэдлэгийн хүрээнд дүгнэлт гаргах, энэ талаар дүгнэлтэд дурдах;

49.1.8.тухайн хэрэг, маргаанд шинжээчээр оролцсонтой холбогдуулан аюулгүй байдлаа хангуулах хүсэлтийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргах;

49.1.9.шинжилгээний байгууллагаас бусад этгээд хийх тохиолдолд томилогдсон байгууллага, шинжээч шинжилгээ хийсэнтэй холбоотой ажлын хөлс, холбогдох бусад зардал олгуулах хүсэлтийг шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдэд гаргах;

49.1.10.хуульд заасан бусад эрх.

49.2.Шинжээч дараах үүрэг хүлээнэ:

49.2.1.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдийн тавьсан асуултын дагуу шинжилгээг тал бүрээс нь бүрэн, бодитой хийж, тогтоосон хугацаанд дүгнэлт гаргах;

49.2.2.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэн хүнлэг харьцах;

49.2.3.шинжилгээ хийх явцад илэрхий болсон төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийг хадгалах;

49.2.4.хэрэгт ач холбогдол бүхий шинэ нөхцөл байдлыг олж тогтоовол энэ талаар дүгнэлтэд тусгах;

49.2.5.шинжилгээнд ирүүлсэн шинжилгээний объектын бүрэн бүтэн байдлыг хариуцах;

49.2.6.шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон бусад этгээдээс хараат бус байж, гагцхүү хуулийн хүрээнд дүгнэлт гаргах;

49.2.7.шинжээчийг шинжилгээ хийхэд саад учруулсан, хараат бус байдалд нөлөөлсөн, нөлөөлөхийг завдсан тохиолдолд шинжээч нөлөөллийн мэдүүлэг гаргаж, дээд шатны удирдлага, эсхүл холбогдох байгууллагад мэдэгдэх;

49.2.8.хуульд заасан бусад үүрэг.

49.3.Нөлөөллийн мэдүүлэг гаргах, хүргүүлэх журмыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.

49.4.Шинжээчийн үйл ажиллагаанд дараах зүйлийг хориглоно:



49.4.1. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээдээс бусад этгээдийн шийдвэр, хүсэлтээр шинжилгээ хийх;

49.4.2. хэргийн оролцогчдын мэдүүлгийг үндэслэн дүгнэлт гаргах;

49.4.3. тухайн шинжилгээтэй холбогдолгүй асуудлаар хэргийн оролцогчоос тайлбар, тодорхойлолт авах;

49.4.4. шаардлага хангахгүй шинжилгээний объектод шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

49.4.5. шинжилгээ хийхийн тулд өөрийн санаачилгаар баримт материал цуглуулах;

49.4.6. шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд болон шинжилгээний хуваарилалтыг баталгаажуулах эрх бүхий албан тушаалтнаас бусад этгээдэд шүүх, прокурорын зөвшөөрөлгүйгээр шинжилгээний үр дүнгийн талаар мэдээлэх;

49.4.7. хуульд зааснаас бусад тохиолдолд шинжилгээний объектыг гэмтээх, устгах, бусдад шилжүүлэх, эсхүл түүний шинж чанарыг өөрчлөх;

49.4.8. шинжилгээний явцад олж мэдсэн төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийг задруулах, түүнийг хувийн сонирхлоор ашиглах;

49.4.9. тодорхой шинжилгээ хийсэнтэй холбогдуулан бусад байгууллага, иргэнээс шагнал, шан харамж авах;

49.4.10. шинжилгээ дууссаны дараа шинжээчийн дүгнэлт, шинжилгээний объектыг өөртөө хадгалах;

49.4.11. шинжилгээний байгууллагын шинжээч шинжилгээний байгууллагаас гадуур шинжилгээ хийж, дүгнэлт гаргах;

49.4.12. шинжээч тавьсан асуултын заримыг санаатайгаар хариулахгүй орхих, эсхүл тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлэх, эсхүл худал дүгнэлт гаргах;

49.4.13. энэ хуулийн 19.1-д зааснаас бусад үндэслэлээр шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;

49.4.14. хуульд заасан бусад.



## **50 дугаар зүйл.Мэргэжилтний эрх, үүрэг**

### **50.1.Мэргэжилтэн дараах эрхтэй:**

50.1.1.өөрийн оролцож байгаа ажиллагаатай холбогдуулан асуулт тавих;

50.1.2.техник хэрэгсэл, төхөөрөмж ашиглах;

50.1.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаа, шүүх хуралдааны тэмдэглэлтэй танилцаж, засвар оруулах хүсэлт гаргах;

50.1.4.албан үүргийнхээ хувиар оролцсоноос бусад гүйцэтгэсэн ажлын хөлс, зардлыг авах;

50.1.5.өөрийн болон бусдын аюулгүй байдлыг хангуулах хүсэлт гаргах;

50.1.6.хуульд заасан бусад.

### **50.2.Мэргэжилтэн дараах үүрэгтэй:**

50.2.1.эрх бүхий этгээдийн дуудсанаар хүрэлцэн ирж, өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбогдуулан мэдүүлэг өгөх;

50.2.2.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагаатай холбоотой асуудлаар оролцогчийн асуултад хариулах, тайлбарлах;

50.2.3.өөрийн оролцсон мөрдөн шалгах ажиллагааны нууцлалыг задруулахгүй байх;

50.2.4.хуульд заасан бусад.

## **НАЙМДУГААР БҮЛЭГ ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГА, ТОГТОЛЦОО, УДИРДЛАГА**

### **51 дүгээр зүйл.Шинжилгээний байгууллага, түүний тогтолцоо**

51.1.Шинжилгээний байгууллага нь эрүүгийн, иргэний, захиргааны, арбитрын хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад ул мөр, эд мөрийн баримтыг илрүүлж, бэхжүүлэх, түүнд үзлэг, үнэлгээ, шинжилгээ хийж, дүгнэлт гаргах тусгай чиг үүрэг бүхий төрийн тусгай алба мөн.



51.2.Шинжилгээний байгууллагын тогтолцоо нь шүүх шинжилгээний төв байгууллага, түүний харьяа алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагаас бүрдэнэ.

51.3.Шүүх шинжилгээний төв байгууллагын харьяа алба, нэгж нь хариуцсан чиг үүргийн хүрээнд нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, үйл ажиллагаагаа шүүх шинжилгээний төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлагнана.

51.4.Нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллага нь үйл ажиллагаагаа шүүх шинжилгээний төв байгууллагын даргын өмнө хариуцан тайлагнана.

51.5.Шинжилгээний байгууллага нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг байна.

51.6.Шинжилгээний байгууллагыг нутаг дэвсгэрийн, эсхүл тойргийн зарчмаар байгуулж болно.

51.7.Энэ хуулийн 51.6-д заасан нутаг дэвсгэрийн зарчмаар нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, газар зүйн байршил, дэд бүтэц, хүн амын тоо, нягтрал, хэрэг, маргааны тоо, бусад онцлогийг харгалзан байгуулна.

51.8.Нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг тойргийн зарчмаар байгуулахдаа харьяалан ажиллах нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын нягтрал, хэрэг, маргааны тоог харгалзан байгуулна.

51.9.Шүүх шинжилгээний төв байгууллагын орон тооны дээд хязгаар, зохион байгуулалтын бүтцийг Засгийн газар тогтооно.

51.10.Шүүх шинжилгээний төв байгууллага үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх нэгжээс гадна сургалт явуулах, шинжээчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа хийх, техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний нэгжтэй байна.

51.11.Шинжилгээний байгууллага нь харьяандаа чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэргэшсэн нэгж, сэтгэл засах, сувиллын нэгжтэй байж болно.

51.12.Шүүх шинжилгээний төв байгууллагын дэргэд салбарын эрдэмтдээс бүрдсэн шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг боловсронгуй болгох санал, зөвлөмж гаргах үүрэг бүхий орон тооны бус эрдмийн зөвлөл байгуулж болно.



51.13.Эрдмийн зөвлөлийн ажиллах журмыг шүүх шинжилгээний төв байгууллагын дарга батална.

## **52 дугаар зүйл.Шинжилгээний байгууллагын туг, бэлгэ тэмдэг**

52.1.Шинжилгээний байгууллага нь туг, бэлгэ тэмдэгтэй байна.

52.2.Шинжилгээний байгууллагын туг, бэлгэ тэмдгийн загвар болон хэрэглэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

52.3.Шинжилгээний байгууллагын туг, бэлгэ тэмдэгтэй ижил загварын туг, бэлгэ тэмдгийг бусад хүн, хуулийн этгээд хэрэглэхийг хориглоно.

## **53 дугаар зүйл.Шүүх шинжилгээний төв байгууллагын чиг үүрэг**

53.1.Шүүх шинжилгээний төв байгууллага нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

53.1.1.алба, нэгж, нутаг дэвсгэр хариуцсан шинжилгээний байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

53.1.2.шинжилгээний байгууллагын хүний нөөцийн бодлого боловсруулах, алба хаагчийг сургаж бэлтгэх, тэдний мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, алба хаагч, ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тэдний ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал, нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

53.1.3.шинжилгээний байгууллагыг техник, тоног төхөөрөмжөөр хангах бодлого боловсруулж, хэрэгжүүлэх;

53.1.4.үндсэн чиг үүргийн хүрээнд дотоод, гадаадын байгууллагатай хууль тогтоомжийн дагуу хамтран ажиллах;

53.1.5.шинжилгээ хийхэд мөрдөх журам, зааврын биелэлтийг зохион байгуулах, түүний хэрэгжилтэд хяналт тавих;

53.1.6.шинжилгээний байгууллага, алба хаагчийн үйл ажиллагаанд хяналт тавьж, алба хаагч, ажилтан гэмт хэрэг, зөрчил үйлдэх, ёс зүй, сахилгын зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх, шалтгаан, нөхцөлийг арилгах, дотоод хяналт, аюулгүй байдлыг хангах;

53.1.7. шинжилгээ хийх үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээ, нээлттэй эх сурвалж ашиглах, мэдээлэл дамжуулах болон бусад хяналтын систем нэвтрүүлэх;

53.1.8. шинжилгээний адилтгал, мэдээллийн нэгдсэн болон төрөлжсөн сан үүсгэх, баяжуулах, ашиглах, шинжилгээ хийх, дүгнэлт гаргах, хуульд заасан төрийн эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах, тэдгээрээс мэдээлэл авах;

53.1.9. хуульд заасан бусад чиг үүрэг.

53.2. Шүүх шинжилгээний төв байгууллага энэ хуулийн 53.1.6-д заасан чиг үүргийн хүрээнд алба хаагч, ажилтны үйл ажиллагаанд төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хувь хүний хуулиар хамгаалагдсан мэдээллийн хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, тэдгээрт холбогдох хууль тогтоомж зөрчих, гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх, шинжилгээний байгууллагын алба хаагч, ажилтанд холбогдох гомдол, мэдээллийг шалгах, шийдвэрлүүлэх зэргээр байгууллага, алба хаагчдын аюулгүй байдлыг хангана.

#### **54 дүгээр зүйл. Шинжилгээний байгууллагын удирдлага**

54.1. Шүүх шинжилгээний төв байгууллага нь дарга, тэргүүн дэд дарга, дэд даргатай байна.

54.2. Шүүх шинжилгээний төв байгууллагын даргаар шинжилгээний байгууллагад 10-аас доошгүй жил ажилласан, улс төрийн албан тушаал эрхэлж байгаагүй, мэргэжлийн болон удирдах ажлын дадлага туршлагатай Монгол Улсын иргэнийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

54.3. Шүүх шинжилгээний төв байгууллагын дарга шинжилгээний байгууллагын үйл ажиллагааг улсын хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө хариуцна.

